

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ 2 САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 03 дүгээр сарын 06

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Монгол Улсын хууль, Улсын их хурлын тогтоол, Улсын их хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн Газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийн хуралдааны тэмдэглэл зэрэг шийдвэрийн заалтуудыг хяналтад авахуулан эзэнжүүлж, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээг тасралтгүй хийж үр дүнг үнэлэх, дүгнэлт гаргах, цаашид шийдвэр гаргах түвшинд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэхэд оршино.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхдээ тайлан, мэдээлэл ирүүлсэн үйл явц, үр дүнг нотолж буй баримтад тулгуурлан хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-д заасан үнэлгээ өгөх аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

2024 оны 2 сарын байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан /unelgee.gov.mn/-д байршуулсан 62 шийдвэр: Засгийн газрын тогтоол-43, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл-44, Засгийн газрын албан даалгавар-5 нийт 92 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж 87.04 хувиар үнэлэв.

- Хэрэгжилтийн үнэлгээний үе шат тус бүрээр нь авч үзвэл:
- Бүрэн хэрэгжсэн 57 заалт нь нийт заалтын 62 хувийг
- Хэрэгжих шатанд 16 заалт нь 17 хувийг
- Хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн 7 заалт нь 0.76 хувийг
- Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй болон аймагт хамааралгүй заалтууд 11 заалт 12 хувийг эзэлж байна.

Дундговь аймагт хэрэгжиж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалт болон хэрэгжилтийн явцыг Dundgovi.gov.mn сайт, төрийн байгууллагын цахим программ болох egr.e-mongolia.mn программын файлын сан хэсэгт байршуулахаас гадна мэдээллийн самбарт байршуулан мэдээллээр ханган ажиллаж хэвшил болоод байна.

Шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцах хуудсаар цохолт хийж, харьяа хэлтсүүд хяналтдаа авахаас гадна төрийн байгууллагын цахим системд бүх төрийн албан хаагчдад нээлттэйгээр байршуулж хяналтад авч байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 87,04 хувьтай байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс үзэхэд Засгийн газрын тогтоол 84,44 хувийн хэрэгжилттэй буюу хамгийн бага хувийн үзүүлэлттэй байгаад тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах бодлогын хэлтэс болон тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх холбогдох агентлагийн удирдлагууд онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр сар бүрийн хэрэгжилтийг хэлтэс агентлагуудад хүргүүлэн, хэрэгжилт, үр дүнгийн үнэлгээг ажил дүгнэх үзүүлэлтэд оруулан дүгнэхээр ажиллаж байна.

Мөн unelgee.gov.mn цахим программд байршуулахдаа хэрэгжиж дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон 11 заалтыг бүрийг нэг бүрчлэн хянаж хяналтаас хасуулах тэмдэглэгээг хийсэн.

ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргахдаа үйл явцыг бус үр дүн, үр нөлөөг тодруулан бичиж нотлох баримтыг хавсаргаж хэвших
2. Шинээр гарч буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийг сурталчлах, иргэдэд мэдээлэх ажлыг эрчимжүүлэн ажиллах.

ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС